



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/850.

Булган сум

### Оны шилдэг ажилтан шалгаруулах тухай

Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын “Журам батлах тухай” 2021 оны А/605 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн шилдэг ажилтан шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны аймгийн шилдэг ажилтнаар шалгарсан иргэд, төрийн албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Шилдэг ажилтнуудын мөнгөн шагнал, урамшуулалд шаардагдах 12,040,000 (арван хоёр сая дөчин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

3. Шилдэг ажилтнуудыг шагнаж урамшуулах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Д.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

